

УЛС ТӨР, ОЛОН
УЛСЫН ХАРИЛЦАА

**ЖАМСРАНГИЙН ЦЭВЭЭНИЙ
СОЦИАЛИЗМЫН ТУХАЙ
ҮЗЭЛ**

Л. Бат-Очир, Д. Уламбаяр

Дорнодахины хоцрогдсон орнууд хөрөнгөтний байгууллыг алгасан нийгэм журамд шилжиж болох тухай марксист-ленинист сургаалыг тусгаар улс орны хувьд Монголын нийгмийн практикт анхлан .

* * *

Намтрын товч: Шарайт овогтой Жамсрангийн Цэвээн (1881—1940) Өвөр Байгалийн Агийн аймагт 1881—4—26-нд төрсөн. 1892-1895 онд Чита хотын гурван жилийн сургууль, 1895—1897 онд Санкт-Петербургийн их сургуулийн Дорнодахины факультетийг тус тус төгссөн. 1907--- 1908 оны зун хүртэл Санкт-Петербургийн их сургуульд монгол хэлний туслах багшаар ажиллаж байв. 1909—1910 онд Өвөрлөгч нутагт шинжилгээний ажлаар явсан. 1911 оны эцсээр Монгол оронд ирж Хаант Монгол Улсын Гадаад явдлын яаманд соёл эрхэлсэн туслах түшмэл, Гадаад яамны дэргэдэх сургуулийн багш, дараа нь «Шинэ толь», «Нийслэл Хүрээний сонин бичиг» сэтгүүлийн эрхлэгч, 1913 оны сүүлээр Хаант Монгол Улсын ерэнхий сайд, Сайн ноён хан Намнан сүрэн, ГЯЯ-ны дэд сайд гүн Б.Цэрэндоржийн хамт Санкт-Петербургт очсон. 1915 оны Хиагтын гурван улсын хэлэлцээрт эксперт, орчуулагчаар оролцсон. 1917 оны 1 сарын хөрөнгөтний ардчилсан хувьсгалын дараа Буриад Монголдоо буцаж Өвөр Байгалийн нийгэм-улс төрийн ажиллагаанд идэвхтэй оролцож 1917 оны XI сард хуралдсан бүх Буриадын IV их хурлаас Төвийн Үндэсний хорооны даргаар сонгогдон 1918—III—23 хүртэл ажилласан. 1918—III—24-VI-5-нд болсон Өвөр Байгалийн Буриад, Казакийн Ажилчин Тариачны Төлөөлөгчдийн их хуралд идэвхтэй оролцож Буриадын секцээс Зөвлөлүүдийн Мужийн Гүйцэтгэх хорооны гишүүнээр сонгогдож, Үндэсний асуудал эрхэлсэн комиссараар томилогдсон. 1919-1920 онд Эрхүүгийн сургуульд Монгол хэлний багш, 1920 оны зунаас Монголын хувьсгалын хэрэгт зүтгэж МАН-ын анхдугаар их хуралд оролцож намд гишүүнээр элссэн. Хувьс алын ялалтын дараа Дотоод яамны дэд сайд (1921—1923), 1923 оноос Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1924 онд Ардыг гэгээрүүлэх яам байгуулахад зөвлөх түшмэл мөн эдийн засгийн зөвлөлийн боловсронгуй гишүүн, Монгол банкны зөвлөлийн гишүүн, «Жизнь бурятий» сэтгүүлийн редакцийн коллегийн гишүүн, оюутны сургуулийн багш зэрэг ажил хийж байв. 1923—1924 онд НТХ-ны тэргүүлэгч гишүүн. 1924— 1925 онд ТХ-ны гишүүн, 1925-1928 онд На мын ХБТҚ-ын орлогч, тэргүүлэгч 1924—1925 онд Улсын Бага хурлын гишүүнээр тус тус сонгогдож байв. «Баруунтан» хэмээгдэж 1929 онд явагдсан намын цэвэрлэгээгээр намаас хөөгджээ. 1928—1930 онд Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1930 1932 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэмтэн гишүүн, 1932—1937 онд Ленинград дахь ЗХУ-ын ШУА-ийн Дорнодахиныг судлах хүрээлэнд

эрдэм шинжилгээний ажил хийж байв. 1919 онд Эрхүүгийн их сургуулийн профессор, 1923 онд Буриадын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн, 1936 онд Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хүртэж удалгүй ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгогджээ. 1937 оны 8-р сард улс төрийн хилс хэрэгт баривчлагдаж хэлмэгдсэн. 1956 онд цагаатсан байна.

* * *

хэрэгжүүлэх нарийн түвэгтэй, ингэхлээрээ өндөр хариуцлагатай үүрэг нам, түүний тууштай удирдагчдад ноогджээ.

Тэд үйл явдлын хурц үзүүр дээр байж улс төрийн зоримог шийдвэр гаргаж өнөө болон ирээдүйн төлөө бүхий л хариуцлагыг өөртөө хүлээх өндөр үүрэгтэйг гүнээ ухамсарлан ойлгож мөн ингэж ажилласан байв. Үүгээрээ ч манай ард түмэн Аугаа их Октябриар нээгдсэн хүн төрөлхтний гэрэлт замыг анхлан замчлагчдын нэг болсон юм.

Гэвч анхлан замчлагчдын хувьд капиталист биш хөгжлийн зам амар хялбар, шулуун толигор байсангүй. Энэ замд амжилтын зэрэгцээ багагүй бэрхшээл тохиолджээ. Энэ нь юуны өмнө анги бүлгүүдийн эрх ашиг, шийдвэрлэвэл зохих хойшлуулшгүй зорилт, үндэсний онцлог, үзэл санааны түүхэн уламжлал, нийгэм-эдийн засгийн бодит байдал түүнчлэн капиталист дайсагнасан хүрээллийн нөхцөлийг тусгасан үзэл суртлын тэмцэл зөрөлдөөн байлаа. Энэ тэмцэл нь МАХН-ын дотор ч өөрийн ул мөрийг гүнзгий үлдээсэн нь зүйн хэрэг.

Үзэл суртлын амьдралд олон янзын урсгал холилдон хутгалдаж байсан нь тэрхүү тэмцэл зөрөлдөөнийг улам төвөгтэй болгож байжээ. Үндэсний ажилчин анги хараахан үүсэж төлөвшөөгүй, нэг хувьсгалын зорилт нийлж хосолсон, үзэл суртлын амьдралд балар эртний ба феодалын, жижиг хөрөнгөтний ба народник мөн шашны суртал хийгээд түүхэн уламжлал зэрэг олон янз урсгал хутгалдсан нь улс орны дотор марксист үзэл санаа бүрэлдэн тогтоход, намын зарим удирдах зүтгэлтний улс төрийн үзэл санаа төлөвшин тогтоход нөлөөлсөн байна.

Түүнчлэн тэд ардын хувьсгалын ялалтын дараа үзэл суртлын хуучин ойлголтоо удаан хугацаагаар хадгалж байснаас тэр нь намын үзэл суртлын үйл ажиллагаанд нэлээд гүнзгий тусч байлаа.

1920-иод оны дундаас МАХН, түүний удирдлагын дотор өрнөсөн үзэл суртлын тэмцэл зөрөлдөөн нь улс орны тусгаар тогтнолыг бататгах, нийгмийн хөгжлийн цаашдын арга замын тухай асуудлаар хэрэг дээрээ хамгийн хурц илэрсэн байна.

Капиталист дайсагнасан хүрээллийн нөхцөл дунд БНМАУ-ын тусгаар тогтнолыг бататгах, цаашдын хөгжлийг хангах талаар улс төрийн зарим зүтгэлтнүүд, өөрсдийн харилцан адилгүй бодол сэдвийг намд санал болгож байв. Энэ нь юуны өмнө Намын Хянан Байцаах Төв Комиссын гишүүн проф. Ж. Цэвээний баримтлалаар илэрлээ олсон байна. Ж. Цэвээн бол Орос улсын Санкт-Петербург хотноо дээд боловсролыг олсон томоохон профессор эрдэмтэн бөгөөд МАХН-ыг байгуулах болон ардын хувьсгалын үйлсэд идэвхийлэн оролцож явсан гавьяатай хүн билээ. Хувьсгалын эхний үед марксист-ленинист боловсрол, шинэ цагийн мэргэжил мэдлэг бүхий боловсон хүчин нэн ховор байсан цагт Ж. Цэвээн эрдэм боловсролтойнхоо хувьд төдийгүй мөн хариуцлагатай ажил эрхэлж байсныхаа хувьд хувьсгалчид, нам, улсын зүтгэлтэн нарт үзэл суртлын талаар нөлөөтэй байлаа.

Профессор Ж. Цэвээн монгол орны нийгмийн хөгжлийн төлөвийг өөрийнхөөрөө төсөөлж байжээ. Тэр нүүдэлчин ард түмний социализмд

орох зам нь марксизм-ленинизмийг үндэслэгчдийн зааснаас нэлээд онцлог ялгаатай байх юм гэж үзээд ...Төв Азийн газар оронд явуулбал зохих ардын нийгэм журмын ёс...¹ буюу «Монгол орны социалист хөгжлийн онцгой зам»² гэсэн баримтлал боловсруулж түүнийгээ монголын нийгмийн хөгжлийн гол мөрийн хөтөлбөр болгох санал дэвшүүлсэн байна.

Энэхүү баримтлалыг нийгэм-улс төр, үндэсний асуудал, эдийн засаг, шашны үзэл, гүн ухааны талаас нь авч үзэж болох юм.

Нийгэм-улс төр, үндэсний асуудлын тал: Шинэ тулгар хөгжиж буй хувьсгалт Монгол улсын дотоод, гадаад байдлыг хангах тэргүүн зэргийн зорилт бол бүх монгол үндэстнийг нэгтгэн авч хүчирхэг их Монгол улсыг байгуулах ингэснээрээ хэнтэй ч эсэргүүцэвч хор аюулыг үзэхгүй хэмээн Ж. Цэвээн үзэж байлаа. Тэр 1924 онд хэлэхдээ: «... Монгол улсын тусгаар тогтнон хүмүүжих явдал манай гадаад монголын нэгэн хэсэг газрын төдийгөөр бат хүчирхэг болон чадахгүй учир эрхбиш монгол язгууртан бүхнийг нэгтгэн авч санаа зоригийг нийлүүлэн гүйцэтгэвэл хэнтэй эсэргүүцэвч хүч чадал, буурай дорой хохирлыг хүлээхэд хүрэхгүй учир намын нэгдүгээр их хуралд монгол язгууртныг нэгтгэх тухай хэргийг шүүмжлэн хэлэлцэж тогтсон зүйл буй боловч өнөө хүртэл үүсгэн шийдээгүй нь манай улсын бас л нэгэн үндсэн Ихээхэн чухал хэрэг хожимдон саатаж, хорыг хүлээх мэдэшгүй тул...энэ тухайг шүүмжлэн хэлэлцэж эрх биш гүйцэтгэн явуулахыг ихэд итгэн горилох бөгөөд эдгээр сануулж илтгэсэн зүйлүүдийг тус тус тайлбарлан шүүмжилж, дутагдсан хожимдсон зэргүүдийг засаж сайжруулах заавар тогтоолыг гаргаж Ардын Нам ба Ардын засгийн хэргийг үүрд бат нотоор дэлгэрүүлэхийг ихэд итгэж»³ байна гэжээ.

Ж. Цэвээн намын анхны программд «Монгол Ардын нам эрмэлзэх нь: алсдаа монгол үндэстэн бүгдээр нийлж нэгэн улс болохыг хүснэ»⁴ гэж тусгасан зүйлээ иш үндэс болгон нам энэ зорилтыг хэрэгжүүлэхэд их л хойрогшиж байна гэж шүүмжилсэн байна.

Тэр монгол орон газар нутгийн хувьд харьцангуй том, харин хүн амын хувьд ихээхэн цөөн, хүн ам ийнхүү сийрэг байгаа нь эрчимтэй хөгжих бололцоогүй болгож байна. Учир иймийн тул улс орны эдийн засаг, соёлыг амжилттай хөгжүүлэхэд хүн амыг ядаж хоёр дахин өсгөх хэрэгтэй гэж үзэж байв⁵.

Иймд Монгол үндэсний төр улсыг бататгахад юуны өмнө дотоод Монгол, Буриад, Халимаг зэрэг Төв Азийн газар оронд бутран тарсан монгол овогт цагаачдыг уугуул нутагт нь нүүлгэж ирүүлэх нь зүйд нийцнэ. Гэхдээ хувьсгалт монгол болох Халх нь эдийн засаг, соёл, эрх зүйн ололт, амжилтаараа үлгэр жишээ үзүүлж бусад Шилийн голын Цахар, Улаан цав, Алаша эзний голын барга цаашлаад Төв Азийн Түвд, Хөх нуур, Синьцзян зэрэг газар орныг өөрөө үлгэрлэн татах ёстой. Үндэсний хувьсгалт хөдөлгөөний өрнөлтийн гол утга учир нь нийт монгол угсаатны холбоог байгуулахад оршино. Үүнд басхүү Дорнод гурван чуулганыг (Жирэм, Зост, Зуу-Уд) сайн дурынх нь үндсэн дээр БНМАУ-д нүүлгэж ирүүлэх хэрэгтэй юм. Тэгэх аваас Халхын хүн ам нягтарч, аж ахуйн боломж өсч, соёл өрнөн хөгжих аятай боломж нэгэнт бүрдэх билээ. Алсдаа ЗХУ-ын дэмжлэгтэйгээр БНМАУ-ыг тойруулан өмнөд этгээдийн Хөх нуур, Түвд, Хятадын Туркестан, умард этгээдийн Тагна-Тува, бусад монгол угсаатны бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотоор төвлөрсөн Төв Азийн Холбоот Улсыг байгуулах нь зохистой⁶. Ийм Холбоот Улсыг байгуулж чадах ахул «Хятад Орос, Япон зэрэг улсуудын алинд ч гишгэгдэхгүй тусгаар тогтносон⁷ ...» биеэ даасан улс болж чадах юм гэж үзэж байв.

Монгол оронд ардын хувьсгал ялсны дараа Дотоод Монгол, Буриад Монгол, Тагна-Тувагийн ард түмэн Монгол Ард Улсад сайн дураараа Нэгдэх хүсэлтэй байгаагаа нэг биш удаа илэрхийлж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй.

Цаашлаад «Төрийн бие даасан байдал жинхэнэ тусгаар тогтнолыг олоход зөвхөн ЗСБНХУ-аар хүлээн зөвшөөрөгдөх төдийгүй мөн Хятад болон бусад гүрнүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой бизээ. Бид хятадын сюзеренит (эзэн эрх-Л.Б.Д.У) ч биш, ЗСБНХУ-ын про: текторат (ивээл асрамжийн дор-Л.Б.Д.У) ч биш харин ЗСБНХУ, Хятад зэрэг улсаас батлагдсан бөгөөд бусад олон улсаас зөвшөөрөн хүлээсэн Швейцари мэт төвийг сахисан улс»⁸ байх ёстой, «чухамхүү Ийм болж чадах аваас Монгол хэмээх хоцрогдсон нэгэн улс орон амар төвшнөөр соёл боловсролын хөгжлөө хангаж чадна»⁹ гэж Жамсрангийн Цэвээн үзжээ.

Тус орны хөгжлийн ирээдүйн талаар «сэтгэл зовон санаа тавьсан» энэхүү баримтлалын нэг тал нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг Чингис хааны эзэнт улсын үеийн төрх байдлаар бататгах гэсэн явдал юм. Ийм үзлийг В. И. Ленин «бага үндэстний их гүрний санаархал» гэж нэрлэж байсан юм. Монгол орныг нийгмийн талаар гол биш, харин үндэстний талаар аль болох их чөлөөлөх явдал гэж үзэж байснаас түүний ухамсарт үндсэрхэх үзэл санаа голлож харин ангийн тэмцлийн үзэл санаа хойш тавигдаж байлаа. «Өмчийн янз бүрийн хэлбэр ба оршин тогтнох амьдрал нийгмийн нөхцөл дээр зүсэн бүрийн өвөрмөц санаа, хоосон горьдлого, элдэв бодол, ертөнцийг үзэх үзлийн бүхэл бүтэн давхрага тогтож байдаг»¹⁰-ийг тэмдэглэх хэрэгтэй.

Зарим улс төрийн зүтгэлтэн шинэчлэгдсэн нөхцөл байдалд шинэ шинэ зорилтыг хэрэгжүүлэх арга замыг зөвхөн үндэстний эрх чөлөөний тэмцлийн үеийнхээ нөхцөл байдлын хүрээгээр сэтгэж байв.

Чухам намын удирдлагад байсан Ж. Цэвээний Монгол улс үндсээ хүчирхэг болгох гэсэн эх оронч санаа сэтгэл нь урагш биш хойш харж байснаараа ихээхэн ноцтой байсан юм.

Учир нь 20-иод оноос Японы милитаристууд шовинист суртал нэвтрүүлгээ дахин хүчтэй болгож түүнийхээ гол баримтлал паназиатизмын (Аугаа Их Азийн) үзэл гэгчийг илэрхий номлох болсон юм.

Тэд Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдлыг гутаан муучилж, Монголчууд оросоос салж цацран мандаж буй наран улсын ивээл дор их Монголын улсыг байгуулан түүндээ Түвдээс Байгаль нуур, Шинжаниас (Сяиньцзян) Хянган хүртэлх оршиж байсан бүх Монгол угсаатныг нэгтгэж Чингис хааны улсыг сэргээх панмонголизмыг дахин дэвшүүлэх зэргээр үндсэрхэх үзлийг илэрхий хөхүүлэн турхирч байлаа¹¹. Чухам ийм үед Ж. Цэвээний баримтлалыг намын бусад зүтгэлтэн ойлгоход бүр ч түвэгтэй байсан нь мэдээж юм.

Ж. Цэвээний баримтлалыг 1928 онд хуралдсан МАХН-ын VII их хурал эрс няцаасан байна. Их хурлын төлөөлөгч Д. Чимид Цэвээн авгайг шүүмжилж хэлэхдээ: «Монгол үндэстнийг нэгтгэхдээ хувьсгалт ёсоор нэгтгэнэ хэмээн гоёмсоглон хэлж буй, жишээлбээс дотоод монголын хойт хагас ойрыг нь аваад чанад Хятадын сурталд автагдсаныг орхиж наадталыг таслаад цаад захыг орхиж нэгтгэх хэмээсэн нь үндэстний явцуу үзэл мөн¹² гээд түүхэн ёсоор тусгаарлагдсан хийгээд даруй цагийн байдал ба хувьсгалын явдлыг харгалзан гүйцэтгэхгүйгээр манай монгол Нэгдэж их улс болъё, хүчирхэг чийрэгт хүрсүгэй хэмээх нь мөнөөхөн түүхэнд дурсагдах Чингисийн үеийн сүр хүчийг дахин мандуулъя хэмээсэн эзэрхэг суртал болуужин хэмээн эргэлзэнэ»¹³ гэжээ. Коминтерний төлөөлөгчдийн тэргүүн нөхөр Б. Шмераль

их хуралд оролцож үг хэлэхдээ зарим төлөөлөгчөөс «Явцуу үндсийг баримтлах буюу монгол үндэстнийг нэгтгэх үзэл болбоос бидний улсад хортой» хэмээснийг дэмжихийн хамт империалист Японоос үзэл суртлын талаар явуулж байсан панмонголын хорт бодлогын мөн чанарыг илчлэн шүүмжилжээ. Тэр хэлэхдээ: «Японы энэхүү лоозон нь Монголын ард түмний ашиг тусын тул бус, гагцхүү Монголын ард түмнийг өөрийн бодлогыг бүтээх хэрэгт шатрын хүү болгон ашиглахыг эрмэлзсэн хэрэг болно. Энэ бодлогын үндсэн чанар нь монголын эрх чөлөөг мандуулж хэмээсэн бус харин Гаолин, Манжуур, Дотоод монголын мэт байдалд оруулахыг эрмэлзсэн нь болно»¹⁴ гэсэн байна.

Гэвч Ж. Цэвээн Намын VII их хурал дээр өөрийн байр суурийг Өөрчлөөгүй, үзэл бодлоо хамгаалан түүнийгээ тайлбарласан ажээ.

Гадаад бодлогын талаар төвийг сахих баримтлалтай нь холбогдуулан хэлэхэд Ж.Цэвээн бүр хувьсгалын өмнө болон хойно тухайлбал 1922 оноос анхдугаар үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын бүрэлдэхүүнд орж* ажиллаж байхдаа Швейцари улсын үндсэн хууль ба үндсэн хуулийн чанартай актууд, түүхийн болон бусад судалгааны зохиол бүтээлийг нэлээд судалж сайхь улсаас авч хэрэглэвэл зохих зүйл байгааг тэмдэглэж байв. Энэ тухай санаагаа үндсэн хуулийн талаар өөрийн оруулсан 24 зүйлийн саналд ч дурдаж байжээ.

Үнэхээр анхдугаар үндсэн хуулийн төсөл боловсруулахад ЗХУ-ын бас Швейцари улсын үндсэн хуулийг ч үлгэр болгосон юм. Энэ тухай улсын анхдугаар их хуралд тавьсан засгийн газрын илтгэлд тэмдэглэхдээ: «...Европын Швейцари хэмээх Бүгд Найрамдах улсын хэдийнээс тогтсоор ирсэн засгийн байдал ба эдүгээгийн Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын тогтсон засгийн байдлыг үлгэр болгон, Зунтон хэмээх их ерөнхийлөгчийн тусгай тушаалыг тавихыг хэрэгсэхгүй болгож, улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах ба улсын их хурлын чөлөө цагт ардын засгийн газрын хуралд хадгалахаар тогтсон болно»¹⁶ гэжээ.

Хамгийн гол нь олон улсаас батлагдсан төвийг сахисан статус нь Швейцари улсыг Дэлхийн нэгдүгээр дайны хөнөөлийн гадна үлдээснийг Ж. Цэвээн гүнээ ойлгож байсан нь тодорхой юм. Тиймээс ч Алс Дорнодод олон улсын байдал нэн нарийн түвэгтэй байсан үед улс орны тусгаар тогтнолыг бататгах хоёрдахь зүйл бол нийгмийн байгууллын ардчилсан шинжийг хадгалж Швейцари мэт төвийг сахисан байх нь чухал гэж үзэж байсан байж ч болох юм. Харин тэр улс орноо хөрөнгөтний замаар хөгжүүлэх гэж Швейцари улсыг үлгэр болгох гээгүй бололтой нь түүний дэвшүүлсэн баримтлалаас харагдаж байгаа юм.

Орчин үед бүс нутгийн мөргөлдөөн, дотоод улс төрийн амьдралаа зохицуулах, намжаах үүднээс Бүгд Найрамдах Камбож Улс, Бүгд Найрамдах Афганистан Улс нийгмийн байгууллын ардчилсан шинжийг хэвээр хадгалах үндсэн дээр төвийг сахисан улс болох тухай тэмдэглэж байгаа нь ихээхэн учир холбогдолтой ажээ.

Нөгөө талд бусдад олон зуун жилээр дарлагдаж байсан бага буурай үндэстнүүд капиталист дайсагнасан хүрээллийн нөхцөлд тусгаар тогтнолоо алдчихвий гэж эмзэглэх, үүнээсээ үүдэн гадаад бодлого

* 1922 оны V—19-нд МАХН-ын ТХ, АЗГ-ын үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссыг Шүүх яамны сайд Магсархурц, Ж. Цэвээн, Ч. Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэйгээр анх байгуулжээ. Уг комисс нэлээд ажлыг гүйцэтгэсэн боловч тогтоосон хугацаанд үндсэн хуулийн төсөл боловсруулж чадаагүй учир 1924 оны хавар татан буугдаж шинээр Б. Цэрэндорж тэргүүтэй комисс байгуулагдахад бүрэлдэхүүнд Ж. Цэвээн, Э. Ринчино, Коминтерны төлөөлөгч Т. Рыскулов нар оржээ.

доо бусад улс оронтой ялангуяа их гүрнүүдтэй харилцахдаа ихэд эмээж болгоомжлох, түүгээр ч зогсохгүй түүнээс холдон хөндийрч байхыг эрмэлздэг ажээ. В. И. Лениний хэлснээр ийм үл итгэх, эмээн болгоомжлох нь бас л «аргагүй, зарим талаар зайлшгүй, зүй ёсны хэрэг»¹⁷ байсныг тэмдэглэх хэрэгтэй юм. Гэсэн хэдий ч тэд үүгээрээ улс хоорондын харилцаанд улам бүр ганцаардмал болж байгаагаа, түүгээр ч зогсохгүй империализмын зууш болж байна гэдгээ ойлгодоггүй юм. Үүний гол алдаа нь пролетарийн хувьсгал ялснаар улс хоорондын харилцаанд цоо шинэ үзэгдэл тодруулж хэлбэл их, бага үндэстнүүдийн хооронд жинхэнэ интернационалч ах дүү ёсны харилцаа буй болсныг олж хараагүй буюу ихээхэн дутуу үнэлсэнд оршино. «Жижиг улсын жижиг хөрөнгөтний үндэстний хязгаарлагдмал байдал нь хөндий зайдуу байх эрмэлзлээр бас дэлхийн түүхийн аугаа их тулалдаанаас холхон байх эрмэлзлээр илэрнэ».¹⁸

Эдийн засгийн тал: Ж. Цэвээний баримтлал нь эдийн засгийн хувьд бол Монгол орон хоршоолол, улсын капитализмаар дамжин социализмд орох ёстой байв. Тухайлбал, хувийн аж ахуйтныг хадгалан дэмжиж ядуучуудыг дундчуудын хэмжээнд хүргэх (өөрөөр хэлбэл 100 хүртэл бодтой) дундчууд болон баячуудыг улам чинээлэг болгох, энэ явцад дунд болон баян чинээлэг аж ахуйтан ажиллах хүчин мөхөсдөж ирэхлээр өөрсдөө зайлшгүйгээр хоршооллын системд урган орно. Түүхий эд, өргөн хэрэглээний асуудал бүгд хоршоололд хамрагдсан, санхүү зээлийн систем улсын банкны гарт, албан татварын систем нь хувийн хөрөнгөлөг этгээдүүдийг хэрэг дээр хавчихад чиглэгдсэн учир иймийн тул 200—300 түүнээс дээш бодтой дунд ба баян чинээлэг аж ахуйтнууд хоршоололд зүй ёсоор хамрагдана гэж тэрээр үзэж байв. Түүнчлэн ой мод, газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн гаргадаг мөн түүхий эд боловсруулдаг үйлдвэр, тээвэр, холбоо, барилга ер нь нийт үйлдвэрийн салбар улсын капитализмд хамрагдсан байх ёстой. Ийнхүү хувийн дунд болон баян чинээлэг мөн нударган аж ахуйтан амьдралын явцаар хоршооллын системд урган орохын зэрэгцээ ерөөс Монгол улс ч бүхэлдээ хоршооллын болон улсын капитализмын хамт дэлхийн социалист маягийн системд гарцаагүй багтан орно»¹⁹ гэж үзжээ.

Проф. Ж. Цэвээн МАХН-ын V их хурал дээр «хүний уул зорилгыг ард олны тусад хандуулбал баяжихыг хориглож болохгүй»²⁰ хэмээсэн бусад нөхдийн саналыг бүрэн дэмжиж хэлэхдээ: «Манай намын гишүүд өөрийн ажил юугаан боловсронгуй сайтар явуулж бусад ард олныг хоосруулахгүй нийтдээ хэм тэгш хөрөнгөжихийг хичээл хэрэгтэй. Баяжих гэдэг үгийг ташааран ухаж болохгүй. Олон нийтээр баяжихыг эрмэлзсэн утга бөгөөд бусдыг мөлжиж хөрөнгөжвөөс үл болно. Хэрэв ард түмнээ үгээгүй хоосны туйлд хүргэж цөөхөн хүн баяжваас эцэстээ улс төр мөхөхийн шалтгаан болно»²¹ гэж «Баяжиг жигтун» лоозонгийн утга учрыг тайлбарласан байна. Намын удирдлагад байсан Ц. Дамбадорж, Н. Жадамбаа, Ж. Цэвээн нарын энэ сэдэв нь эцсийн бүлэгт ардын аж ахуйтны ядуу доод, дунд хэсгийн аж амьдралыг дээшлүүлэх тэдний мал аж ахуйгаа өсгөх хувийн сонирхолыг нь дээшлүүлэх гэсэн эдийн засгийн бодол санаа байсныг ер үгүйсгэж болохгүй юм. Гэвч бодит байдал, хэлсэн үг хоёр нэлээд хол зөржээ. Дээрх сэдэв нь (гадаадын капиталыг шахан зайлуулаагүй, феодалын хөрөнгийг хураагаагүй байсан нөхцөлд эдийн засгийн аргаар мөлжих хандлагатай болсон феодал агсадын аж ахуйгаар нөгөө талаас ардын аж ахуйтны чинээлэг хэсэг хөдөөгийн нударган баячууд, худалдаа гүйлгээний хүрээнээс шинэ тутам төрж байсан үн

дэсний хөрөнгөлөг этгээдийн ашиг сонирхолд илүүтэйд нийцэж ингэснээрээ намын бодлого жанжин шугамд харшилж улс орны эдийн засгийг «капиталист» чиглэлээр хөгжүүлэхийг улс төрийн хувьд зөвтгөсөн лоозонгийн шинжтэй болсон байна. «Баяжигтун» лоозон хөрөнгөлөг этгээдийг хөлжиж хөгжихөд ашигтай болсны улмаас 1927 онд хүн амын дөнгөж 2,1 хувийг эзэлж байсан 3000 гаруй баян аж ахуйтан нийт малын 24,7 хувийг²² эзэмшиж байжээ. 1924 онд 1-10 хүртэл бодтой ядуу өрх бүх аж ахуйтны 25 хувь байсан бол 1927 онд 33 хувь²³ гаруй болж дундчуудын тоо илэрхий цөөрсөн байна. Ийнхүү дээрх бодлогын улмаас ардын аж ахуйтны дотоодод ангийн ялгарал ихсэж феодал, чинээлэг аж ахуйтны дундаас хөдөөгийн хөрөнгөлөг маягийн аж ахуй нэмэгдэхэд хүрчээ. МАХН-ын VIII их хурал энэ тухай тэмдэглэхдээ «Аж ахуйн хэргийг хөгжүүлэхэд ангийн чанарыг харгалзан явуулсангүйн улмаас... Шинэ баячууд хөгжихийн нөхцөл бүрджээ²⁴» гэж дүгнэсэн нь учиртай ажээ.

Нөгөө талд ЗХУ-д хэрэгжүүлж байсан эдийн засгийн шинэ бодлого манай оронд их нөлөө үзүүлсэн байна. В. И. Ленин Шинэ нийгмийг байгуулахад (тэгэх тусмаа нийгмийн хөгжлийн хувьд доогуур төвшинтэй улс оронд социализмыг байгуулахад улсын капитализмыг идэвхтэй ашиглахын чухлыг нэг биш удаа онцлон тэмдэглэж байв. В. И. Ленинийг нас барсаны дараа Н. Бухарин эдийн засгийн шинэ бодлогыг цаашид үргэлжлүүлж 1925 онд «Баяжигтун» гэсэн лоозонг албан ёсоор гаргаж иржээ.

Тэр үед намын удирдлагад байсан зарим зүтгэлтэн аж ахуйг эдийн засгийн сонирхол дээр хөтлөн явуулах, үндэсний хөрөнгөлөг этгээд гадаадын капитал, пүүсүүдийг эдийн засгийг хөгжүүлэхэд идэвхтэй ашиглах, капиталист орнуудтай худалдааны хүрээнд хамтран ажиллах, нийгмийн байгууллын ялгааг үл харгалзан нийт хүн төрөлхтний үнэт зүйлээс суралцах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байсан бололтой. Үүнд бас капиталист орнуудын эдийн засгийн түр тогтворжилтын амжилт нөлөөлсөн нь эргэлзээгүй бизээ. Гэвч «баяжигтуц» хэмээх лоозонгийн эдийн засгийн агуулга, түүнийг хэрэгжүүлэхэд гаргасан алдаатай үйл ажиллагаа хоёрыг ялган салгаж задлан шинжилсэнгүй, мөн хэрэгжүүлж болох үр ашигтай өөр арга замыг ч олж туршсангүй, бүхэлд нь няцааж буруутгаж тийнхүү «зүүний» үйл ажиллагаа газар авч эхэлжээ.

Шашин гүн ухааны тал: «Үндэсний социализмын» баримтлал нь шашны сурталтай нягт уялдаж байлаа. Проф. Ж. Цэвээн шашныг өөрчлөгдөж байгаа түүхийн шинэ нөхцөлд тохируулан хөгжүүлж Гэхдээ түүнд шинэтгэл хийхийг оролдож марксизм-ленинизмийг буд дизмтай адилтгаж, буддын сургаал намын сурталд харшлахгүй харин ч нийлэх тул түүнийг «ариунаар мандуулах» түүнд суралцахын чухлыг цохон тэмдэглэж байв.

Дээрх лоозонг сэдэгч Ж. Цэвээн өөрийн философийн үзлийг бичих дээ: «Аугаа их Готама* коммунизмын төгс сургаалыг орчлон ертөнцөд хайрлан соёрхжээ...Түүний орчин үеийн ойлголт Готамагийн буддагаас Ленин хүртэлх үзэсгэлэнт гүүр тавьж байна. Тухайлбал чин зоригтой байх ёс, ангийн болон гадаад ялгааг үл харгалзан бие хүний

* —1926—1929 онд Германд 40, Францад 4 хүн сурч байв. Улаанбаатар дахь Төмрийн болон Түйпүүн заводад германы техникийн экспертүүд ажиллаж байжээ. НТХ-ны дарга Ц. Дамбадорж 1926 оны зун Герман, Итали, Франц улсад очиж байсан юм.

* Готама-эртний Энэтхэгийн философич, МЭӨ П зуунаас МЭ-ийн П зууныг хүртэл үргэлжилсэн философийн НАЯА системийг үндэслэгч

нэр төрийг хүндэтгэх ёс, бодит мэдлэгийг дээдлэх ёс, өөрийн ухамсрын үндсэн дээр бусдыг энэрэн хайрлахуй ёс энэ бүгд нь суут багш нарын гэрээслэлийг хүн төрөлхтний баяр баясгалангийн тасралтгүй солонго болгож байна. Жинхэнэ буддын сургаалыг Ленин яаж үнэлж байсныг бид мэднэ. Бид түүний гэрээслэлийн дагуу Буддын сургаалийн үндсүүдийг бүтээн байгуулах болно»²⁵ гэжээ. Ж. Цэвээн (эртний Монголын түүх, соёл, буддын гүн ухааны уламжлалыг өөртөө шингээсний зэрэгцээ, шинжлэх ухааны социализмын онолтой ямар нэг хэмжээгээр танилцаж маркс-лениний зарим бүтээлээс монгол хэлнээ хөрвүүлэн нийтэлж байсан боловч энэ сургаалийн ертөнцийг хувьсган өөрчлөгч мөн чанарыг гүйцэд ойлгох шатанд хараахан хүрээгүй юм.

Гэхдээ тэр жинхэнэ шашны үзэл, буддын сургаал хоёр бол эрс ялгаатай гэж ойлгож байв. «К. Маркс шашныг хар тамхины утаа хэмээсэн нь тусгай учиртай бөгөөд энэ нь зөвхөн христос, лал мэтийн эзэрхэг суртлын шашинд өгсөн үнэлэлт, иймийн тул манай бурханы суртаалд огт хамаарахгүй юм. »²⁶ Хэрэв К. Маркст буддын сургаалийн талаар арвин материал байсан бол тэрээр сонирхолтой дүгнэлт хийх байсан хэмээн үзэж байв.

«Манай ардын намаас бурханы сургаалийг ариунаар мандуулах зорилт нь сүм хийдэд сууж ном цаазын ёсоор санваараа ариун сахин явагч жинхэнэ лам хуваргуудыг дотнолон үзэж байгаа хэрэг. Мөн буддын сургаалийг ийнхүү дотнолон үзэж байгаагийн гол утга учир нь бурхан шигмуны сургаал номонд хамгийн нарийн учир шалтгаанныг үндсээр нь шинжлэх үнэн зөвийг олсон нь маш гүн болоод элдэвчлэн шинэчилбэл шалгадаг ухаанд (шинэжлэх ухаан) үл харшлан харин ч лавтайяа нийлцэх тул үнэхээр бишрэн хүндэтгэж дотночлон үзсэн хэрэг болно...Иймийн тул зүйл нь бурханы шашныхаа утга чанар ёс суртлыг аль болохуйц судлан танилцаж шашны тухай хэргийг шүүмжлэхдээ буруу зөвийг бүдүүвчлэн ялгаж чадах болбоос сайн»²⁷ хэмээн Ж. Цэвээн үзэж байлаа. Профессор, байгаль дэлхийг бурхан бус өөрийн хууль зүйгээр хөгждөг, дэлхий ертөнц хумхийн тоосноос бүрэлдэн тогтсон, өөрөө байнга хувьсан өөрчлөгдөж байдаг, нар дэлхийг тойрдоггүй, дэлхий бөөрөнхий хийгээд нарыг тойрдог гэх зэрэг байгалийн шалтгааныг олон үзэгдлийн тухай, мөн хамаг амьтныг энэрч хайрлах, амар амгаланг тогтоох тухай сэдэв санааг эртний буддын гүн ухаанаас олж харсан бөгөөд ингэхлээрээ буддын сургаал марксын суртал лугаа нийцэж байгаа юм гэж ойлгож байв. «Диалектик сэтгэлгээ тухайлбал тэр нь зөвхөн хүнд байдаг ухагдахууны өөрийн нь шинж чанарыг судлах явцад (буддистуудад болон грекүүдэд) хөгжлийн харьцангуй өндөр хэмжээнд хүрсэн бөгөөд өөрийн бүрэн хөгжил нь хожим одоогийн философит хүрсэн юм.»²⁸ гэж Ф. Энгельс өөрийн үед бичсэн байдаг.

Дээрх үзэл нь проф. Ж. Цэвээний (Буяндалайн хамт) 1926 онд хэвлүүлсэн «Орчлон ертөнцийн байдлыг товчлол үзүүлсэн дэвтэр»²⁹ «Община»³⁰ зэрэг бүтээлүүдэд тусгагдсан байна:

Марксизмыг буддизмтай адилтгах гэсэн оролдлого нь нэг талд хүмүүсийн ухамсарт шашны үзэл суртлын нөлөө хүчтэй байсан, нөгөө талд шинжлэх ухааны социализмын үзэл санаа Монгол оронд түгэн дэлгэрч байсныг харуулж байна. Түүнчлэн ертөнцийг үзэх эсрэг тэсрэг үзлүүд өөр хоорондоо зөрчилдөж нөгөө талд нийгэмд хувьсгалт өөрчлөлт гүнзгийрч марксист-ленинист сургаал нийгмийн амьдралд алхам алхамаар зонхилох үзэл суртал болохын хирээр тэдгээрийг хооронд нь зохицолдуулахыг оролдсон улмаар энэ нь эсрэг тэсрэг ангиудыг үзэл суртлын хувьд эвлэрүүлэх үүнийхээ хамт түүнийг онолын үндэслэлтэй болгоход дэм болж байв.

Марксист-ленинист сургаалийг үндэсний хэв загварт оруулж, түүнийг шашны өнгө аятай болгох оролдлого нь басхүү Ази, Африкийн орнуудад одоо ч түгээмэл үзэгдсээр байгаа юм.

МАХН-ын VII их хурал шашны талаарх Ж. Цэвээн авгайн байр суурийг хурц шүүмжилсэн байна. Их хуралд хурлын тэргүүлэгч төлөөлөгч З. Шижээгээс шүүмжлэхдээ: «...Европт марксын суртал лугаа Мөн энэ мэтээр дүрслэн реформизм суртал дэлгэрснийг кишээлбээс герман улсын Бернштейн гэдэг хүнээс Мөн марксын суртлыг тэрслэн эдүгээ түүний (Бернштейн) суртал бол олон түмэн үйлдвэрчний цусыг урсгаж капитал хөрөнгөтний хурц зэвсэг оруулж байгааг хэнээрч мэдэх тул мөн нөхөр Жамсрановоос энэ мэтээр буддын балар суртлыг марксын суртал лугаа тэрслүүлэн Монголын ядуу ба дунд ардыг дахин гал усны гашуун аюулд оруулах хэмээсэн хортой бодлого болов уу хэмээн санана...Нөхөр Жамсрановын үзэл суртал бол хэзээ ч маркс-лениний суртал лугаа нийлэхгүй буйзаа»³⁰ гэсэн байна. Гэвч өнгөрсөн түүх, соёлын дэвшилтэт өв сан, буддын гүн ухааны доторхи диалектик санааг шарын шашны бурангуй үзлээс ялган салгаж зааглаж үзсэнгүй аанай л феодалын суртал хэмээн бүхэлд нь эрс няцааж тийнхүү түүх, соёлын дэвшилт өв санг устгах, шашин, сүшиг бишрэлийг хооронд нь ноцтой будлиантуулсан уршигт үйл ажиллагааны эх үндэс чухамдаа энэ үеэс тавигдаж эхэлжээ.

Ж. Цэвээний баримтлал эдүгээгийн Ази, Африкийн орнуудад гарч байгаа «үндэсний социализмын» олон янзын марксист биш үзэл онолтой нийтлэг. Ерөөс Ж. Цэвээний баримтлал нь гурав дахь ертөнцөд» дэлгэрсэн «үндэсний социализмын» олон янз үзэл онолын анхны илрэл байсан гэж үзэж болох юм.

Хөрөнгөтний хөгжлийг нийгмийн системийнх нь хувьд үгүйсгэсэн нь энэ баримтлалын дэвшилттэй тал мөн. Ийм баримтлал гарах болсон нь монгол оронд марксист-ленинист сургаал нэвтэрч байсан баримт юм. Ер нь үндэсний социализмын» үзэл сурталчдын олнхи нь өөрсдийн болоод өөрийн нам, улс төрийн бүлэглэлийн ертөнцийг үзэх үзэл бүрэлдэн тогтоход марксизм-ленинизм нөлөөлснийг хүлээн зөв шөөрсөн байдаг. Социализмын хувьсгалт ардчилсан үзэл санааны нэрт төлөөлөгч Кваме Нкрума «Залуухан байхдаа В. Гегель, К. Маркс, Ф. Энгельс, В.И. Лениний бүтээлийг уншсан явдал миний ертөнцийг үзэх үзэл бүрэлдэн тогтоход нөлөөлсөн»³² гэжээ. «Африкийн социализмын» нэрт үзэл сурталч Сенегалийн ерөнхийлөгч Л.С. Сенгор «Сене-галын социализмын» асуудлыг боловсруулахдаа К. Маркс, Ф. Энгельс, орчин үеийн томоохон философич Тейяр де Шардэны бүтээл, «Арабын социализмын» онол, Африкийн үзэл санааны өв «Негрийнд-ийн» үнэ тэй цэнэтэй бүгдийг ашигласан»³³ гэж бичсэн байдаг.

Ж. Цэвээн монгол орныг социализмд дэвшүүлэн хөгжүүлэх зорилтыг ер үгүйсгээгүй, харин онцлогтой шилжих тухай тэмдэглэж байжээ. Түүний баримтлалын дутагдалтай тал нь үндэсний онцлогийг хэтрүүлэн үнэлсэн, феодал анги, баян чинээлэг аж ахуйтны хөрөнгийг хураахгүйгээр, улс орныг ангийн тэмцэлгүйгээр, үндэсний ажилчин ангигүйгээр жижиг өмчтөнд тулгуурлан нийгэм журмын ёсонд шилжүүлэх гэснээрээ утоп социалист народник шинжтэй болсон юм. Иймэрхүү үзлийг В И Ленин «Народник үзэл тодорхой хэмжээгээр бүхэл бүтэн тууштай суртал байв. Орос оронд капитализмын ноёрхолыг үгүйсгэж байв бүх пролетари нарын тэргүүний тэмцэгч болсон фабрик заводын ажилчдын ролийг үгүйсгэж байв...жижиг хөдөө аж ахуйчтай тариачдын хүй нэгдэлд түшиглэн шууд социалист эргэлт хийхийг номлож байв»³⁴ гэж түүний мөн чанарыг тодорхойлсон юм.

Ж. Цэвээний үзэл онлын алдаа нь ихэнхдээ танин мэдэхүйн шинжтэй байсан гэж хэлж болохоор юм.

«Үндэсний социализмын» төв Азийн хувилбар гэж хэлж болох энэ хүү баримтлал гарах болсон нь санамсаргүй тохиолдол биш бөгөөд харин нийгэм-эдийн засгийн бодит нөхцөлтэй холбоотой, үзэл санаа, онолын эх үндэстэй ажээ. Энэ үзэл нь өөрийн орны үндэсний хэлбэр түүхэн уламжлал ба марксист-ленинист сургаалын нөлөөн дор бүрэлдэн, барууны орнуудаас нэвтэрч агсан жижиг хөрөнгөтний үзэл суртлын нөлөөнд нэрвэгдсэн мөн шашны уламжлалыг өөртөө гүнзгий агуулсан ажээ. В. И. Ленин орос орон хоцрогдмол байгаа учраас социализмын янз бүрийн хоцрогдсон сургаал манай оронд бат бэх байгаа юм гэж тэмдэглэж байв.³⁵ В. И. Лениний энэ заалт капитализмын өмнөх болон жижиг таваарын аж ахуй мэдэгдэхүйц байртай, эдийн засгийн хувьд нэлээд хоцрогдсон хувьсгалын ардчилсан шатны зорилт шийдвэрлэгдэж дуусаагүй байсан манай оронд социализмын марксист биш баримтлал үүссэн бас нэг шалтгааныг тайлбарлаж байв.

Үзэл суртал түүний дотор социалист олон янзын сургаалуудыг Шинжлэх ухааны үүднээс ангилах сонгодог жишээг К. Маркс, Ф. Эн гельс, В. И. Ленин нар үзүүлсэн билээ. Түүнийг арга зүйн удирдлага болгож «Үндэсний социализмын» олон янз үзэл баримтлалуудыг 1-рт хувьсгалт ардчилсан үзэлтнүүдийн социализм, 2-рт үндэсний хөрөнгөтний «социалист» үзэл номлол гэсэн үндсэн чиглэлд хуваадаг.

Хувьсгалт ардчилсан үзэл бол капитализмын өмнөх болон капитализмын түрүү шатанд оршиж байгаа улс орнуудын нийгмийн давхаргын улс төрийн тэмцлийн үйл явц дахь социализмыг талархсан эв нэгдлийн үзэл бөгөөд энэ нь империализм, капитализм, феодализмын эсрэг чиглэсэн, ардчилсан, хөдөлмөрчин олон түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлсэн байдаг. Хувьсгалт ардчилсан үзэлтнүүдийн социализм бол тариачид (малчин ард), жижиг хөрөнгөтөн, дэвшилт эх оронч үзэл бүхий сэхээтэн, бичгийн түшмэл, цэргийн зүтгэлтний хэсэг, хот хөдөөгийн радикал үзэл санаатай давхаргуудын (түүнчлэн ажилчин ангийн ашиг сонирхлыг тусгасан сургаал мөн).³⁶ Энэ баримтлал империализмын эсрэг чиглэлтэй капитализмын эсрэг бодит арга хэмжээнүүдийг авч явуулахаар шийдвэрлэж байгаагаараа хөрөнгөтний «социалист» номлолуудаас өөр юм. Хувьсгалт ардчилсан үзэлтнүүдийн тэргүүний хэсэг нь шинжлэх ухааны социализмд нэлээд олон талаар ойр бүхий үзэл санаануудыг дэвшүүлж байна. Үндэсний хөрөнгөтний «социализмын» үзэл санаануудын философийн үндэс нь идеализм байхад хувьсгалт ардчилсан социализм үзэл сурталчид олон асуудлаар материалист чиглэлийг баримталж байна. Чухам энэ үүднээс авч үзвэл Ж. Цэвээний хоршооллын социализмын баримтлал нь хувьсгалт ардчилсан социализмын үзэлд багтана гэж хэлж болох юм.

Түүний үзэлд соён гэгээрүүлэх, народник, утоп социализм, үндсэрхэх үзэл, буддизм болон марксизмын үзэл холилдож байжээ. Гэхдээ ерөөс цэврээрээ оршдог хувьсгалт ардчилсан үзэл гэж байдаггүй бн" лээ. Тэрээр өөрийн үеийн хувьсгалт ардчилсан үзэлтний томоохон төлөөлөгч байжээ. Профессор Ж. Цэвээний нийгэм-улс төр, гүн ухааны үзлийг тунгааж үзэхэд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Хятадын доктор Сунь Ятсен, Энэтхэгийн М. Ганди, Ж. Неру, Египетийн г. Насер, Индонезийн А. Сукарно, Ганын К. Нкрума, Конгын П. Лумумба, Гвинейн А. Секу Туре нарын үзэл баримтлал, үйл ажиллагаатай олон талаар ижил төстэй байгаа юм уу гэсэн дүгнэлт санаа аяндаа төрж байна.

Гэхдээ Монгол орныг социализм тийш чиглүүлэн хөгжүүлэх асуудлыг боловсруулах гэж оролдсон энэхүү томоохон бөгөөд зөрчилтэй төлөөлөгчийн үзэл онол, бүтээлийг цаашид нягтлан судлах хэрэгтэй юм.

- ¹ Заявление Ц. Жамсрано в ЦК МНРП НТА Ф. 1, Т. 4. ХН. 99-д
- ² Мөн тэнд
- ³ МАХН-ын III их хурал. УБ., 1966. 21 дэх тал
- ⁴ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966, 34 дэх тал
- ⁵ НТА Ф. I Т. 4 ХН 99-д
- ⁶ Мөн тэнд
- ⁷ Мөн тэнд
- ⁸ Мөн тэнд
- ⁹ Мөн тэнд
- ¹⁰ К. Маркс, Ф. Энгельс, Түүвэр зохиол. Ш боть, 465 дахь тал
- ¹¹ Г. Дэмид. Гадаад байдал ба манай зорилтууд. УБ., 1933 14—15 дахь тал
- ¹² МАХН-ын VII их хурал. УБ., 1980. 185 дахь тал
- ¹³ Мөн тэнд
- ¹⁴ МАХН-ын VII их хурал. 112 дахь тал
- ¹⁵ УТТА. Ф. II. Т., ХН 10
- ¹⁶ БНМАУ-ын анхдугаар их хурал. УБ., 1984, 35 дахь тал
- ¹⁷ В. И. Ленин. Зохиолууд. 30-р боть, 285 дахь тал
- ¹⁸ В. И. Ленин Зохиолууд. 23 боть, 84-р тал
- ¹⁹ НТА. Ф. I, Т.4, ХН 99
- ²⁰ МАХН-ын V их хурал, УБ., 1981, 37—38 дахь тал
- ²¹ Мөн тэнд
- ²² Хозяйство Монголии. No 5, 1929. с. 19—20
- ²³ МАХН-ын VII их хурлын дэлгэрэнгүй тогтоол. , тэргүүн дэвтэр. УБ., 1929, 384 дахь тал
- ²⁴ МАХН-ын их, бага хурал. , Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол шийдвэр. УБ., 1956, I хэсэг, 205 дахь тал
- ²⁵ «Основы буддизм» предсловае. Улаанбаатар. , 1999. С. 1
- ²⁶ МАН-ын V их хурал. УБ., 1980. 37 дахь тал
- ²⁷ ХЗЭ ба Буддын шашин, ХЗЭ., N 9, 1927 он. 16-22 дахь тал
- ²⁸ К. Маркс, Ф. Энгельс. соч. Т. 14, с. 430
- ²⁹ Ж.. Цэвээн (Буяндалайн хамт) Орчлон ертөнцийн байдлыг товчилсон үзүүлсэн дэвтэр. УБ., 1926 он 1-р бүлэг. «Нарт ертөнцийн анх тогтсон ба ялах ёс», 2 бүлэг. «Газар усны төлөв» 3 бүлэг «Ус салхины зүйл ургамал ба адгуусан амьтан, хүн төрөлхтний төлөө»
- ³⁰ «Община» Улаанбаатар. 1927
- ³¹ МАХН-ын VП их хурал. 230 дахь тал
- ³² Е.С. Троицкий. Немарксистких концепций социализма и борьба за общественный прогресс В странах Азии и Африки. М., 1974, с. 35
- ³³ Мөн тэнд
- ³⁴ В. И. Ленин. 12 боть. Түүвэр зохиол. 5-р боть. 37 дахь тал
- ³⁵ В.И. Ленин. , Зохиолууд., 9-р боть. , 450 дахь тал
- ³⁶ Социалистическая ориентация освободившихся стран. Некоторые вопросы Теории в практики. М., 1982, с. 104 - 105.